

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДААС ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН БИЕЛЭЛТ

**/2010 оны байдлаар жилийн эцсийн байдлаар/**

**1.Аймгийн иргэдийн нийт ашиг сонирхлыг илэрхийлж, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.**

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх үүднээс аймгийн Засаг даргын Тамгын газарт холбогдолтой 14 бүлгийн 68 стратегийн арга хэмжээг зохион байгуулан хэрэгжилтийн хангуулан ажиллаа.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудад хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хүргүүлсэн бөгөөд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2011 оны үндсэн чиглэлийг уялдуулан батлуулсан.

Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт жилийн эцсийн байдлаар 93,6 буюу хангалттай хэрэгжиж байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх, байгууллага бүр өөрсдийн нөөц боломжид тулгуурлан үйл ажиллагааны дэвшилд хүрэх арга замыг эрэлхийлж, ажлын уялдаа холбоог сайжруулан төрөлх нутгаа хөгжүүлэх эрхэм зорилгыг дэвшүүлсэн 9 зарчмыг тулгуур ойлголт болгон нийт ажилтан, албан хаагчдад түгээн орон нутгийн хэмжээнд мөрдлөг болголоо.

Дорнод аймгийн Засаг дарга, Тамгын газраас өнгөрөгч 2010 онд “**Төр- иргэний харилцаа хамтын ажиллагаанд тулгуурлан үйл ажиллагааны дэвшилд хүрэх**” зорилт дэвшүүлэн зарлаж үйл ажиллагаагаа чиглүүлэн зохион байгуулж ажиллаа.

Дэвшүүлсэн зорилго нь орон нутгийг удирдахад иргэдийн үр ашигтай ,идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд адил тэгш боломжийг олгох, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хийж бүтээх хүсэл эрмэлзлэл төрүүлэх, хууль эрх зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, сургалтад хамруулах чиглэлүүдээр шийдвэр гарган, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

**2. Засаг төрийн төлөөлөгчийн хувьд батламжаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн хууль ёсыг чандлан сахиж, Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг удирдлага болгон ажиллана.**

Аймгийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хууль эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг зохион байгуулах, мөн аймаг, сумын

Засаг даргаас гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон захирамжийг хянаж хуульд нийцүүлэх талаар журам гарган хяналт тавьж ажиллаж байна.

Аймгийн Засаг даргаас шийдвэрлэж байгаа аливаа асуудлыг Хууль зүйн хэлтсээр урьдчилан хянуулан эцэслэн гаргаж хэвшсэн.

Хууль тогтоомжийг чанд мрдөн, хүний эрхийг хангах талаар анхаарч ажиллаж ирлээ. Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд хуулиудын хэрэгжилт 80-95 хувийн биелэлттэй байна.

Аймгийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Монгол улсын хууль тогтоомжийг сурталчилах эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх “Эрх зүйн туслалцааны төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлж хэвшлээ.

Мөн аймгийн [www.dornod.mn](http://www.dornod.mn), [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) е-майл хаягаар “Эрх зүйн туслалцааны төв”-ийн талаар танилцуулга мэдээлэл хийж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмж, Захиргааны хэргийн шүүхээр эрхээ хамгаалуулах тухай хуулийн асуулт хариулт зэргийг байршуулан иргэдэд хүргэж ажлыг зохион байгуулсан.

**3. Нутгийн захиргааны байгууллагыг ажил эрхлэх ур чадвар, мэдлэг боловсрол, туршлагатай, мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэн төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар үйлчилнэ.**

Батламжаар хүлээсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс өөрийн аймгийн нутгийн захиргаа байгууллагыг ажил эрхлэх ур чадвар, мэдлэг боловсрол, туршлагатай, мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэх, төрийн албаны залгамж халааг бэлтгэх тал дээр анхаарч ажиллаж ирлээ.

Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрсний дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас баталсан “2010 онд Удирдлагын академид зохион байгуулах Засгийн газрын захиалгат сургалт, судалгааны ажлын төлөвлөгөө”-ний дагуу Засгийн газрын захиалгаар Удирдлагын академийн магистрантад 3, төрийн удирдлагын менежерээр 6, төлбөртэй ангид төрийн удирдлагаар 3, бизнесийн удирдлагаар 4, нийгмийн удирдлагаар 1 иргэнийг тус тус сургаж байна.

Төрийн албыг мэргэшсэн албан хаагчаар бэхжүүлэх үүднээс Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран төрийн албан мэргэшлийн шалгалтыг шат дараатай зохион байгуулж төрийн албаны ажиллах хүчний нөөцийг бүрдүүлэх зорилгоор ээлжит мэргэшлийн шалгалтыг зохион байгууллаа.

Төр засгийн бодлого шийдвэр, аймаг орон нутгаас зохион байгуулж байгаа ажлын талаарх мэдээллийг [www.dornod.mn](http://www.dornod.mn), [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) болон “Дорнод” сонинд нийтэлж, иргэдэд мэдээлж ажилласан.

#### **4. Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг байнга сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авилгал, хээл хахуультай тууштай тэмцэж ажиллана.**

Аймгийн ИТХ-аас 2010 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 323.5 сая төгрөг /үүний 269.0 сая төгрөгийг улсын төсвийн тодотголоор орон нутгийн төсвийн эх үүсвэр болгон өөрчилсөн/, аймгийн төсвийн харилцах дансны үлдэгдлээс 216.3 сая төгрөг, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр 140.9 сая төгрөг буюу орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 663.2 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүс нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр 2800.0 сая төгрөг, ЭМЯ, ХХААХҮЯ, ЗГХЭГ, БОАЖЯ, БСШУЯ-ны сайдын багцаас худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлсэн 879.9 сая төгрөгийн нийт 3679.9 сая төгрөгийн 36 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус баталсан.

Дээрх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, шалгарсан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан тоног төхөөрөмж, барилга байгууламж, их засварын ажлуудыг хугацаанд нь гүйцэтгүүлэн санхүүжилтийг төлөвлөсөн хуваарийн дагуу олгосон.

Орон нутгийн төсвийн тэнцэл 2010 онд төлөвлөсөн хэмжээнээс 2.5 хувиар буюу 108.6 сая төгрөгөөр сайжирснаар төсвийн тэнцлийг төлөвлөсөн хэмжээнээс 0.2 хувиар сайжруулах талаар аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилтыг 12.5 дахин давуулан биелүүллээ.

#### **5. Аймгийн бодит эдийн засгийн өсөлтийг ханган ажиллахын зэрэгцээ, соёл боловсрол, эрүүл мэндийн зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулан ажиллана.**

**Соёл, боловсролын талаар:** Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд ” Сумдын соёлын төвийн үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд хөгжмийн зэмсэг, техник хэрэгслээр хангах ажлыг үргэлжлүүлэн иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ” зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэх зорилгоор сумдын соёлын төвүүдийг хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан улсын төсвөөс 2008 онд 25.0 сая төгрөгийн, 2009 онд 15.1 сая, 2010 онд бүх сумдад 35.0 сая төгрөгийн нийт 75.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгээд байна.

2010 онд сумдын соёлын төвүүдэд улсын болон орон нутгийн төсвөөр нийт 177234283 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Эдгээр арга хэмжээний үр дүнд соёлын төвүүдийн хөгжмийн зэмсэг техник хэрэгслийн хангамж сайжирч, соёлын ажилтнуудын

мэдлэг чадвар нэмэгдэж, иргэдэд үйлчлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.

2009-2010 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 5 настай 1187 хүүхэд байгаагаас 870 нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан 317 нь хамрагдаж чадаагүй дүн гарсан. СӨБ-д хамрагдаж чадаагүй эдгээр хүүхдүүдийг хувилбарт сургалтанд бүрэн хамрууллаа. 2009-2010 оны статистик мэдээгээр СӨБ-д хамрагдагсдын тоо 118-аар өсч хамран сургалтын цэвэр **жин 3.3 хувиар** ахисан.

2010 онд сум бүрт 2-оос доошгүй гэр цэцэрлэг ажиллаж хамран сургалтын хувь бохир жингээр 74%, цэвэр жингээр 65.4% болж өнгөрсөн хичээлийн жилээс 0.1% өссөн.

2010 онд хувилбарт сургалтаар 14 суманд 18 гэр цэцэрлэг ажилласан нь өнгөрсөн оныхоос гэр цэцэрлэгийн тоо 5-аар нэмэгдсэн бөгөөд 504 хүүхэд хамрагдсан. Статистик мэдээгээр СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо 3659 болж хамран сургалтын цэвэр жин 65.4 хувь буюу өмнөх жилээс 0,1 хувиар ахисан. “Тогтвортой амьжиргаа 2” төслийн 15,1 сая төгрөгийн санхүүжилтээр Баян-Уул сумын Бэрх багт 20 хүүхдийн цэцэрлэг шинээр барьж ашиглалтанд өгөөд байна.

2009-2010 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр 1-р ангид 1248 хүүхэд элсэн орсон нь өмнөх оноос буурсан байна. Элсэлт буурсан шалтгаан нь тухайн онд төрөлт багассан, насандаа сургуульд элсээгүй хүүхдийн тоо буурсан, өмнөх хичээлийн жилд 6 настай хүүхдийн 98%-ийг сургуульд хамруулж, насандаа сургуульд ороогүй хүүхдийг сургуульд хамруулах зорилт тавин ажилласантай холбоотой. Элсэгчдийн 104 нь 5 ба түүнээс доош настай, 1054 нь 6 настай 129 нь 7-9 настай хүүхэд байгаа бөгөөд 6 настай хүүхдийн 63.4% нь СӨБ-д хамрагдсан байна.

2010-2011 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 1327 хүүхэд элсэн орсны дотор 5 настай 159, 6 настай 1105 хүүхэд байгаа ба 6 настай хүүхдийн хамрагдалт 91,2 хувьтай байна. 2010 онд улс, аймаг орон нутгийн болон БСШУ-ны сайдын хөрөнгө оруулалтаар Цагаан-Овоо сумын сургуулийн ус цэвэршүүлэх төхөөрөмжийн сэлбэгт 2.0 сая, Сэргэлэн, Хөлөнбуйр сумдын сургуулийн уурын зуухны засварт 70.0 сая, Гурванзагал сумын сургуулийн дотуур байрны засварт 156.0 сая, Булган сумын сургуулийн спорт заалны барилгад 202.700.0, Хөлөнбуйр сумын сургуулийн хичээлийн байрны их засварт 40.0 сая, Хан-Уул цогцолбор бага сургуулийн засварт 70.0 сая төгрөгийг, Хэрлэн суманд 640 хүүхдийн сургуулийн барилгад 600.0 сая төгрөгийн, 6 дугаар цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж 15.0 сая, Матад сумын цэцэрлэгийн барилгад 100.0 сая төгрөгийн, Цагаан-Овоо сумын сургуулийн дотуур байранд хөрөнгө оруулалт хийснээс гадна 450.0 сая төгрөгийн компьютерээр хангасан байна.

2010-2011 оны хичээлийн жилд албан бус боловсролд 504 хүүхэд хамрагдаж байгаагаас эмэгтэй 123 байна. Бага боловсролд 230, суурь 232, бүрэн дундад 42 хүүхэд хамрагдаж байна. Үүнээс суурь боловсролын төгсөх ангид 130, бүрэн дундын төгсөх

ангид 17 хамрагдаж байна. 104 нь 24-өөс дээш насных, нийт хүүхдийн 21 нь сургуульд огт ороогүй хүүхдүүд байна.

Орон нутгийн төсвөөр Сэргэлэн сумын сургуулийн дотуур байрны дээвэрт 1.900.000, “Тогтвортой амьжиргаа-2” төслөөс Булган сумын цэцэрлэг, сургуульд тус бүр 5.0 сая төгрөгийн, 14 дүгээр цэцэрлэгт 4 сая төгрөгийн гал тогооны төхөөрөмж нийлүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын соёлын төвүүдийг хөгжим, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан улсын төсвөөс 2008 онд 25.0 сая төгрөгийн, 2009 онд 15.1 сая, 2010 онд бүх сумдад 35.0 сая төгрөгийн нийт 75.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

### ***Халамж, хөдөлмөр эрхлэлтийн талаар:***

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээнд 3542 иргэн хамрагдаж, 274249.4 мянган төгрөг зарцууллаа. Ажил идэвхтэй хайж 1389 иргэн шинээр бүртгүүлж, үйлчилгээ авч 1136 иргэн хасагдаж сарын эцэст 984 бүртгэлтэй иргэд байна. Ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 1524 иргэн хамрагдаж, ажил олгогчидтой идэвхтэй хамтран ажилласны үр дүнд тус хэлтэст 1540 ажлын байрны захиалга ирснээс 1524 иргэнийг ажлын байранд зуучилснаас 264 иргэнийг байнгын, 414 иргэнийг улирлын, 846 иргэнийг түр ажлын байранд зуучиллаа.

Мэргэжлийн анхан шатны чиг баримжаа олгох сургалтад итгэмжлэгдсэн сургалтын байгууллагатай хамтран худалдагч касс нярав, гар утасны засварчин зэрэг 12 төрлийн сургалтад 346 иргэн хамрагдаж 49344.2 мянган төгрөгийг зарцуулаад байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 14 сумын Засаг даргын Тамгын газартай хамтран малын сэг зэм устгах, “Чойбалсан хөгжил” ОНӨҮГ-тай хамтран хог хаягдлыг цэвэрлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулж нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж нийт 846 иргэн хамрагдаж, 79600.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын тендерт шалгарсан ХААН банктай хамтран ажиллах гэрээ байгуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 505.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж одоогийн байдлаар нийт 181 иргэнд 259.1 сая төгрөгийн зээл олгож, эдгээрийн үр дүнд 333 ажлын байрыг шинээр бий болгосоныг [www.ejob.mn](http://www.ejob.mn) вэб сайтад бүртгэж мэдээллээд байна. Хэлтэс, банк, иргэний хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу зээлийн хүүгийн нөхөн төлбөрийг 29 иргэнд 3705.7 мянган төгрөг олгосон байна. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 27 байгууллагын 54 иргэн хамрагдаж, 26032.4 мянган төгрөгийг зарцуулаад байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд Булган, Чулуунхороот, Чойбалсан сумдын 15 залуу малчдыг БНХАУ-ын Хайлаар хотын Эвенк хошууны фермерийн аж ахуйтай танилцуулж, мал авах, хашаа хороогоо сайжруулах,

бага оврын МАА-н тоног төхөөрөмж авахад нь зориулж тус бүрд нь 2.0 сая төгрөг, мөн дээрх малчдад бага оврын трактор 5.0 сая төгрөгөөр, малчин бүр 800.000 мянган төгрөгөөр мал авах дэмжлэг үзүүлж, нийт 27.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

### ***Нийгмийн халамжийн талаар:***

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хөдөлмөр эрхлэх, орлогын эх үүсвэртэй болоход нь туслах 91 өрхийн 294 иргэнд 18920.0 мянган төгрөгийг олгоод байна. Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж халамжийн үйлчилгээг олон улсын жишгээр хөгжүүлэх зорилгоор Хэрлэн, Баянтүмэн сумын ахмадын хороотой хамтарсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдрийн үйлчилгээнд нийт 155 иргэнийг хамруулж, нийт 18750.0 мянган төгрөгийн санхүүжилт олгоод байна. Мөн сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ, сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээнд 498 иргэн хамрагдаж, 11350.0 мянган төгрөг зарцуулаад байна

**6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга хариуцлагыг сайжруулж өндөр шаардлагатай ажиллана.**

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл хуралдаж 2010 онд хийх ажлын төлөвлөгөөг 4 бүлэг 34 заалттай хэрэгжүүлэхээр батлан ажиллаж байна. Гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын албан хаагч, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нийтийн эргүүлд татан оролцуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 72 дугаар захирамжаар хуваарь батлаад нийтийн эргүүлд төрийн байгууллагууд гарч нийгмийн хэв журмыг сахиулах ажилд оролцож байна. Мөн хуулийн хэрэгжилтийг хангах сургалт сурталчилгаа мэдээллийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх орон нутгийн сүлжээний үйл ажиллагааг дэмжиж 3.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.

Монгол улсын хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ГХУСАЗСЗ, АЗДТГ, Цагдаагийн газар, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар хамтран архи согтууруулах ундаагаар үйлчилгээ явуулдаг дэлгүүр, баар цэнгээний газруудад үзлэг шалгалт хийлээ. Архидан согтуурах явдлын шалтгаан нөхцлийг тогтоох түүнийг арилгах арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 216 дугаар захирамжаар “Архидан согтуурахтай тэмцэх аймгийн дэд “ хөтөлбөрийн батлуулж хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

**7.Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Шадар сайдаас өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцааг авч ажиллана.**

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд Засгийн газрын 172 шийдэрийг хяналтад авч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа. Үүнээс:

Ерөнхийлөгчийн зарлиг 3, Ерөнхий сайдын захирамж 2, Улсын их хрулын тогтоол 4, Засгийн газрын албан даалгавар 2, Засгийн газрын тогтоол 138, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 24 хяналтад авч холбогдох мэргэжилтэн, агентлагуудад хүргүүлэн биелэлтийг хангууллаа.

Аймгийн хэмжээнд Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 2010 оны хугацаанд 93.7 хувийн биелэлттэй хэрэгжиж байна.

Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд улирал бүр дүн шинжилгээ хийж үнэлгээг аймгийн удирдлагуудад танилцуулан тогтоосон хугацаанд дээд газарт хүргүүлэн ажиллаж байна.

**8.Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авилгал хээл хахуульд оролцсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан зэрэг тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу шийтгэл, хариуцлага хүлээнэ**

Энэхүү зорилтын хүрээнд 2010 онд цаг үеийн болон өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй зохион байгуулсан, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулаагүй 7 сумын Засаг даргад сахилгын шийтгэлийг аймгийн Засаг даргын захирамжаар ногдуулж цаашид ажлын хариуцлагыг дээшлүүлэх санамж өгсөн.

Өнгөрсөн оноос эхлэн аймгийн нийт төрийн байгууллагын төрийн албан хаагчид ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэдэггүй орчинг бүрдүүлэх чиглэлээр олон арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн ажил болсон бөгөөд байгууллага бүр хөдөлмөрийн дотоод журам, дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байна.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЖАНЛАВ



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДААС ДОРНОД АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН БАТЛАМЖИЙН БИЕЛЭЛТ**

2011.03.20

/2010 оны жилийн эцсийн байдлаар/

д/д	Шийдвэрийн нэр	Холбогдолтой заалт	Биелсэн	Хэрэгжилтийн явц					Гүйцэтгэлийн хувь
				90-100	70-80	50-60	0-50	тасарсан	
1	Монгол улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламж	8	8	8	-	-	-	-	100.0

**ЗАСАГ ДАРГА**

**Ц.ЖАНЛАВ**